



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/160

Хужирт сум

Аж ахуйн нэгжийн ээлжит тооллого
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-ийн “з” дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын “ Аж ахуйн нэгжийн ээлжит тооллогын улсын комисс томилох тухай” 2021 оны 315 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны “Аж ахуйн нэгжийн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг томилох тухай” А\525 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аж ахуйн нэгжийн 2021 оны ээлжит тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Дэмбэрэл- Засаг даргын орлогч

Гишүүд: Б.Цэрэннадмид-Татварын улсын байцаагч

Р.Ариунбаатар- Улсын бүртгэгч


Д.Мягмарсүрэн-4 дүгээр багийн Засаг дарга

Ц.Лхамролом-5 дугаар багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбат- Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

2. Тооллогыг холбогдох удирдамж, заавар чиглэлийн дагуу тооллогын бэлтгэл ажлыг ханган зохион байгуулж тоологч нарын халдвар, хамгаалал, аюулгүй байдлыг ханган ажиллаж тайлан мэдээг нэгтгэн 2021 оны 12 дугаар сарын 03-ны дотор холбогдох газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч Б.Дэмбэрэлд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

620100319